

ТОГТВОРТОЙ НООЛУУР ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦ СИСТЕМ БИЙ БОЛГОХ НЬ ТӨСӨЛ



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ТОНОО төсөл нь AVSF байгууллагын тогтвортой ноолуурын нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх зорилгоор 2017-2019 онд хэрэгжүүлсэн төслийн үргэлжлэл юм. Энэ хугацаанд төслийн баг Баянхонгор аймгийн долоон суманд малчдын хоршоод байгуулж, чадавхижуулахад дэмжлэг үзүүлж, Тогтвортой ноолуур Гэрчилгээжүүлэлтийн схемийг санаачлан хэрэгжүүлэх замаар малчдын төвшинд тогтвортой ноолуурын нийлүүлэлт, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх загварыг бий болгосон юм.

2021-2024 онд ТОНОО төсөл тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн уг загвар, арга барилыг түгээн дэлгэрүүлж, Тогтвортой ноолуурын Гэрчилгээжүүлэлтийн схемийг үндэсний хэмжээнд баталгаажуулж, Монгол ноолуурын үнэ цэнэ, ялгарлыг бий болгоход хувь нэмэр оруулан ажиллаж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн цогц систем бий болгох нь - ТОНОО” төсөл нь тогтвортой ноолуурын нийлүүлэлт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, орон нутагт байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлж, алсдаа бэлчээрийн доройтлыг бууруулах, цөлжилтийг сааруулахад хувь нэмэр оруулахыг зорин.

7 сумын



4253
өрх



7575
малчин



101 БАХ
7 Хоршоо

4 сая гаруй

га газарт бэлчээрийн менежментийн
төлөвлөгөө хэрэгжүүлэх

Тогтвортой ноолуур
Гэрчилгээнд

хамрагдахад дэмжлэг үзүүлэх

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн санхүүжүүлэгчид:

Дэлхийн байгаль орчны төлөө
Францын сан
Европын холбоо
Европын нэхмэлийн хувийн
компани

Төслийг хэрэгжүүлэгчид:

AVSF Монгол
Тогтвортой ноолуур холбоо
Wildlife Conservation Society

Төсөл хэрэгжих хугацаа:

2021-2024 он

Төсөл хэрэгжих сумд:

Баянхонгор аймгийн
Бөмбөгөр, Баацагаан,
Жинст, Богд, Шинэжинст,
Баянцагаан, Баян-Өндөр сумд



ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

ТОГТВОРТОЙ НООЛУУР
БЭЛТГЭЛИЙН БҮТЦИЙГ
БЭХЖҮҮЛЖ, ОРОЛЦОГЧ
ТАЛУУДЫН ЧАДАВХЫГ
САЙЖРУУЛАХ

ТОГТВОРТОЙ НООЛУУР
БЭЛТГЭЛИЙН САЙН
ТУРШЛАГА, ЗАГВАРЫГ
ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

ТҮҮХИЙ ЭД
НИЙЛҮҮЛЭЛТ,
БОРЛУУЛАЛТЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ

БАЙГАЛЬ ОРЧИН,
НИЙГМИЙН
ҮР НӨЛӨӨНД
МОНИТОРИНГ ХИЙЖ,
СУРТАЛЧЛАХ

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

Баянхонгор аймгийн бэлчээр ашиглагчдын хэсгийн загвар болон хоршооллын системд суурилсан тогтвортой ноолуур бэлтгэлийн арга барил бэхжиж, хүлээн зөвшөөрөгдөнө

Тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн загварыг түгээн дэлгэрүүлэх нөхцлүүд бүрдэж, тогтвортой ноолуурын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх сайн жишээ болж хөгжсөн байна

Тогтвортой ноолуур үйлдвэрлэлийг дэмжих санхүүгийн хөшүүрэг, Монголын тогтвортой ноолуурын зах зээлд гарах боломжууд төрөлжиж, нэмэгдсэн байна.

Тогтвортой ноолуур бэлтгэлийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөг баталж, шийдвэр гаргалтанд нөлөөлөх боломжтой болно.



Тогтвортой ноолуур
Гэрчилгээ бүхий
малчдын төлөөлөл



“Тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн
цогц систем бий болгох нь” төсөл

Хаяг: Баянхонгор аймаг, Баянхонгор сум,
Голомтын ногоон байр, 4-р давхар, 403 тоот
Утас: +976-70440579

ХИЙСЭН АЖЛУУД

Баянхонгор аймгийн долоон сумын БАХ,
✓ Хоршоодыг чадавхижуулж, 4 орчим сая га газарт
бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх нөхцөл
бүрдүүлсэн

Нийт 25 шалгуур бүхий Тогтвортой ноолуур
✓ Гэрчилгээжүүлэлтийн загварыг хэрэгжүүлж, 350
өрхийн 1500 гаруй малчинд Тогтвортой ноолуур
Гэрчилгээ олгосон

Тогтвортой ноолуур Холбоотой хамтран Хоршоодыг
✓ гадаад, дотоодын зах зээлтэй холбож, 20
гаруй компанид тогтвортой ноолуурыг тогтмол
нийлүүлдэг болсон

Аймгийн Газрын албатай хамтран бэлчээрийн
✓ хяналт, судалгаа хийж, бэлчээрийн үзүүлэлтүүдээр
мэдээллийн сан үүсгэсэн

Шинээр байгуулагдсан хоршоодод түүхий эд хүлээн
✓ авах, хадгалах, борлуулах зориулалттай агуулах
байрыг шинээр барьж, сумдад хүлээлгэн өгсөн.